

1. Төслийн товч мэдээлэл

Улаанбаатар хотоос баруун зүгт 30 км-т Хан-Уул дүүрэг 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Шар Хөцийн хоолой” гэх газар 160 га талбайд жилд 8,3 сая арьс шир боловсруулах, 22 мянган тонн ноос ноолуур угаах хүчин чадалтай хөнгөн үйлдвэрийн парк байгуулагдана.

Төслийн нийт хөрөнгө оруулалт 322.1 сая US\$

- Дэд бүтцийн хөрөнгө оруулалт 148.6 сая US\$
- Үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалт 173.5 сая US\$

Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг сонирхсон хөрөнгө оруулагчид нь “Хөрөнгө оруулалтын тухай хууль”-д заасан хэлбэрүүдээр доорх төслүүдэд хөрөнгө оруулалт хийх боломжтой юм.

Паркийн эдийн засгийн үр ашигтай төслүүд

Хүснэгт 2

№	Нэр	Хүчин чадал, үзүүлэлт	Хийгдэх ажил
1	Технологийн усан хангамж	6 гүний худаг, 5.6 км урттай шугам татаж, 2х2500м ³ усан санд хуримтлуулна,	Усны барилга байгууламжийн угсралтын ажил
2	Ундны усан хангамж	5 гүний худаг, 19 км урттай шугам татаж, 2х350 м3 усан санд хуримтлуулна,	Усны барилга байгууламжийн угсралтын ажил
3	Цэвэрлэх байгууламж	Хоногт үйлдвэрийн 12600 м ³ , ахуйн 7400 м ³ бохир ус цэвэрлэх байгууламж,	ТЭЗҮ, Ажлын зураг төсөл, Бүтээн байгуулалтын ажил
4	Дулааны станц	103 МВт дулаан, 100тн/цаг уур үйлдвэрлэнэ.	ТЭЗҮ, Ажлын зураг төсөл, Бүтээн байгуулалтын ажил

Паркийн эдийн засгийн үр ашиг багатай төслүүд

Хүснэгт 3

№	Нэр	Хүчин чадал, үзүүлэлт	Хийгдэх ажил
1	Паркийн инженерийн шугам сүлжээ салбар	2.2 км урт хонгилын систем, цахилгаан хангамж, дулаан хангамж, технологийн уур, холбоо, технологийн ус, ундны ус, ариутгах татуургын шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажил,	Бүтээн байгуулалтын ажил
2	Логистик болон химийн төвийн барилга		Ажлын зураг төсөл, Бүтээн байгуулалтын ажил
3	Шинжлэх ухаан инновацийн төв	4000 м2 талбай бүхий барилга	Ажлын зураг төсөл, Бүтээн байгуулалтын ажил
4	Төмөр зам	Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн 13 хороо Сонгиноны төмөр замаас 8.3 км урттай салбар төмөр зам татна.	ТЭЗҮ, Ажлын зураг төсөл, Бүтээн байгуулалтын ажил
5	Үзэсгэлэн худалдааны барилга		Ажлын зураг төсөл, Бүтээн байгуулалтын ажил

Улс нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төслүүд

Хүснэгт 4

№	Нэр	Хүчин чадал, үзүүлэлт	Хийгдэх ажил
1	Үндсэн цахилгаан хангамж	110/35/10 кВ дэд станц, 2,2 км 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын хамт,	Бүтээн байгуулалтын ажил
2	Паркийн хамгаалалтын бүс	10256 м хашаа	Бүтээн байгуулалтын ажил
3	Парк доторх авто зам	18.38 км урт	Бүтээн байгуулалтын ажил
4	Цэцэрлэгжилт, ногоон байгууламж	Паркийн ногоон байгууламж	Ажлын зураг төсөл, Бүтээн байгуулалтын ажил
5	Оффисын барилга	2900м ² талбай бүхий барилга	Ажлын зураг төсөл, Бүтээн байгуулалтын ажил
6	Үер усны байгууламж	Сувгийн урт 7.1 км, Ус хуримтлуулах 98012, 2294 м ³ эзэлхүүнтэй 2 усан сан,	Бүтээн байгуулалтын ажил